

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн засварын төсөл ("Өвсний үндэс" хөтөлбөрийн буцалтгүй тусламж)

Үндэслэл

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэг нь 1971 онд баригдсан 2 давхар барилгад үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2002 онд цэвэр усны холболт, дээврийн засвар болон хэсэгчилсэн дотоод засал хийгдсэн боловч тус барилга баригдсанаас хойш их засвар хийгдээгүйн улмаас элэгдэл хуучралаас үүдэх эвдрэл гэмтэл их байв. Мөн цэцэрлэгийн ойр орчимд бага насны хүүхдүүдтэй айл өрх олноор амьдардаг ба тус цэцэрлэгээс өөр цэцэрлэг ойр хавьд нь байхгүйн улмаас хүүхэд багачуудыг тус хуучин барилгын

аюул эрсдэлтэй орчинд хүмүүжүүлэхээс өөр аргагүй байсан байна. Иймд Хэнтий аймгийн захиргаа тус цэцэрлэгийн барилгыг цаашид 30~40 жил ашиглах боломжтой болгох их засварыг хийх шаардлагатай хэмээн үзэж, үүнд шаардагдах хөрөнгийг шийдэх хүсэлтийг Японы Засгийн газарт тавьсан. Уг хүсэлтийн дагуу Япон улсын Засгийн газар нийт 83,000 орчим долларын буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх шийдвэрийг 2009 онд гаргасан.

(Тайлбар)

"Өвсний үндэс" буцалтгүй тусламжийн хөтөлбөр нь хөгжиж буй орнуудын олон талын хэрэгцээ шаардлагыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 1989 оноос хэрэгжиж эхэлсэн хөтөлбөр бөгөөд, тухайн хөгжиж буй орны хөдөө орон нутгийн олон нийтийн байгууллага, боловсрол, эрүүл мэндийн байгууллага эсвэл тухайн оронд үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон орон нутгийн ТББ-уудаар дамжин хэрэгжих харьцангуй жижиг төслүүд (төслийн өртөг 100,000 долларт багтах)-ийг тухайн оронд байрлах Япон улсын Элчин сайдын яамаар дамжуулан санхүүжүүлдэг хөтөлбөр юм.

Агуулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн байрыг засварлах (нийт талбай 1,157 м²) (Хүүхэд хүмүүжих аюулгүй бөгөөд таатай орчинг бүрдүүлэх зорилгоор тааз болон шалыг засварлах, цонхнуудыг шинэчлэх, бохирын шугам сүлжээ тавих, паар болон цахилгаан монтажийг сайжруулах зэрэг ажлууд хийгдсэн)



Засвараас өмнө



Засварын дараа

Үр дүн

Засварын ажил 2010 оны 8-р сард дуусч, тус цэцэрлэгийн 207 хүүхэд болон 27 багш ажилтны хичээл, хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаж, Хэнтий аймгийн Хэрлэн суманд сургуулийн өмнөх насны боловсролыг олгох үйл ажиллагаа саадгүй явагдах орчин нөхцөл бүрдсэн. Засвар хийгдсэнээс хойш тус цэцэрлэг нь аймагтаа анх удаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг

хүлээн авах зэргээр шинэ үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба үүний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагчдад цаг завын боломж гардаг болсон байна. Ийнхүү энэхүү төсөл нь тус цэцэрлэгийн хүүхдүүд болон багш ажилтнууд төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагчдад ч үр ашгаа хүртээсэн төсөл болсон юм.